



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/177

Номгон

"Заг-Байдрагийн Хүрэнбэлчир-2023" Монгол  
Туургатны Харвуул их наадмыг зохион  
байгуулах тухай

Баянхонгор аймгийн Заг, Жаргалант сумдын нутаг "МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО"-нд ХҮРЭН БЭЛЧИР хэмээн тэмдэглэгдсэн түүхэн газрыг олон нийтэд таниулан сурталчлах, цаашид аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Соёлын өвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 12/54 дүгээр тогтоолын хавсралтын 1.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Заг-Байдрагийн Хүрэн бэлчир-2023" Монгол туургатны харвуул их наадмыг 2023 оны 07 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд "Заг-Байдрагийн Хүрэн бэлчир"-т зохион байгуулсугай.

2.Монгол туургатны Харвуул их наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Харвуул их наадмын үйл ажиллагаанд шаардагдах төсөв, зохион байгуулах ажлын тусгай төлөвлөгөө гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Үндэсний сурын холбооны тэргүүн (Ц.Отгонбаяр), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар), Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа), Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг) нарт үүрэг болгосугай.

4.Монгол туургатны Харвуул их наадмын цар хүрээ, оролцоог тэлж, тархан суурьшсан Монгол үндэстэн болон гадаад улс орны харваачид, дотоод, гадаадын жуулчдын оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, иргэдийн орлого олох боломжийг бүрдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, өв соёл,

642310441

2.

үндэсний спортын төрлийг үр дүнтэй хөгжүүлэн зохион байгуулахыг ажлын хэсэгт, Харвуул наадамд оролцох жуулчдын тоон судалгааг нарийвчилж гаргахыг аймгийн Статистикийн хэлтэс (Г.Ганчимэг), Хүрээлэн байгаа орчин, эко системийн тэнцвэрт байдлыг хангаж ажиллахыг Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа (Б.Бат-Өлзий) нарт үүрэг болгосугай.


5.Түүхт Заг-Байдрагийн Хүрэн бэлчирт байгуулсан Чингис хааны гэрэлт хөшөө, түүний 9 өрлөг, Чингис хаан, Ван хаан хоёрын хоноглосон газарт байгуулсан дурсгалын хөшөө зэргийг сэргээн засварлаж аялал жуулчлалын бүтээгдэхүүний хэмжээнд тохижуулах, түүхийн тайлбарыг тусгайлан бэлтгэж сурталчлахыг Соёл, урлагийн газар (Ц.Азбаясгалан), Заг сумын Засаг дарга (Г.Нямжаргал) нарт үүрэг болгосугай.

6.Наадмын үйл ажиллагаа, зохион байгуулалт дээр дэмжлэг үзүүлэх иргэд, ААН-ийн оролцоог хангах, орлого олох, худалдаа үйлчилгээ явуулах боломжийг бүрдүүлж ажиллахыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар (Г.Энхтүвшин), бүх сумдын Засаг дарга нарт үүрэг болгох, сумдын ИТХ-ын дарга нарт зөвлөсүгэй.

7.Монгол туургатны Харвуул их наадмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нарт уриалсугай.


8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын ~~О.В.~~ <sup>О.В.</sup> оны ~~24~~ <sup>24</sup> дүгээр сарын ~~07~~ <sup>07</sup> -ны өдрийн ~~21977~~ <sup>21977</sup> дугаар захирамжийн ~~1~~ <sup>1</sup> дүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Отгонбаяр	Баянхонгор аймгийн Үндэсний сурын холбооны тэргүүн
Гишүүд:	
Н.Эрдэнэбат	Харвуул наадмын зөвлөх
С.Баярмагнай	Харвуул наадмын зөвлөх
С.Үнэнбуян	Харвуул наадмын зөвлөх
Ю.Болдбаатар	Харвуул наадмын зөвлөх
Ц.Төмөрбаатар	Харвуул наадмын зөвлөх
А.Мандах	Харвуул наадмын зөвлөх
П.Отгонбаяр	Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга
Т.Хишигбаатар	Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Б.Наранбаяр	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
С.Байгалмаа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Г.Нэмэхбаяр	Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, Хурандаа
Э.Ганзориг	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Мөнхбаяр	Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа
Ж.Алтангэрэл	Онцгой байдлын газрын дарга
Ц.Азбаясгалан	Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
У.Балжинням	Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Оюунбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга

Д.Алтангэрэл	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
Ж.Алтанцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Г.Ганчимэг Ц.Баясгалан	Статистикийн хэлтсийн дарга "Цэвэр хот" ОНӨҮГ-ын дарга
Р.Пүрэвсүрэн Б.Пүрэвдагва	Түүх угсаатны зүй, байгалийн музейн дарга Хөгжимт драмын театрын дарга
Ж.Батболд	Хүүхдийн Тэмүжин театрын дарга
Б.Бат-Өлзий	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга
Ц.Батхүү	Зэвсэгт хүчний 339-р ангийн Захирагч
Г.Энхтүвшин	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбарын дарга
Г.Нямжаргал	Заг сумын Засаг дарга
Д.Мөнхжаргал	Жаргалант сумын Засаг дарга
Б.Гантулга	Гурванбулаг сумын Засаг дарга
Д.Лхагвадорж Г.Доржбат	Бууцагаан сумын Засаг дарга Галуут сумын Засаг дарга
Д.Пүрэвсүрэн	Баянбулаг сумын Засаг дарга
С.Сумъяабазар	Хүрээмарал сумын Засаг дарга
М.Баярсайхан	Бөмбөгөр сумын Засаг дарга
Ж.Хатанбаатар	Баян-Овоо сумын Засаг дарга
С.Эрдэнэменх	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Мэргэжилтэн
М.Батбаяр	Баянхонгор-Хүн үүслийн өлгий аялал жуулчлалын холбооны тэргүүн, Шаргалжуут рашаан сувиллын газрын дэд захирал
Б.Мөнх-Эрдэнэ	Баянхонгор аймгийн Үндэсний сурын холбооны нарийн бичгийн дарга
Д.Сайнбилэг	Жаргалант сумын Үндэсний сурын холбооны тэргүүн
Нарийн бичгийн дарга: Д.Содномсамдан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлалын ахлах мэргэжилтэн

96  
Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дүгээр сарын  
07-ны өдрийн А.М.Т. дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 04 дүгээр сарын 07

Номгон

"Заг-Байдрагийн Хүрэн бэлчир-2023" монгол  
Туургатны харвуул их наадмын харвуул тэмцээн  
зохион байгуулах тухай

**Нэг. Зорилго:**

Баянхонгор аймгийн Заг, Жаргалант сумдын нутаг "МОНГОЛЫН НУУЦ  
ТОВЧОО"-нд ХҮРЭН БЭЛЧИР хэмээн тэмдэглэгдсэн түүхэн газрыг олон нийтэд  
таниулан сурталчлах, цаашид аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх иргэдийн  
ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх, Монгол Үндэстний Эрийн гурван наадмын нэгэн  
төрөл, Үндэстний өв соёлын бахархал сурын харвааг Монголын үндэстэн, ястны  
уламжлагдаж ирсэн төрлөөр сэргээн хөгжүүлэхэд тэмцээний зорилго оршино.

**Хоёр. Харвуул тэмцээн явагдах газар, хугацаа:**

Монгол Туургатны Харвуул Их наадам нь 2023 оны 07 дугаар сарын 19, 20,  
21-ний өдрүүдэд Баянхонгор аймгийн Заг, Жаргалант сумын нутаг "Хүрэн  
бэлчирт"-т болно.

**Гурав: Танилцуулга**

"ХҮРЭН БЭЛЧИР" бол Нууц товчооноо тэмдэглэгдсэн түүхт газар мөн

Монголын их хөлгөн судар болох "Монголын нууц товчоо"-ны 159-р зүйлд  
"Тэндээс Чингис хаан Ван хан хоёр буцаж явахад, Найманы хатгалдагч Хөгсэгү  
Сабраг баатар, Байдраг бэлчирт цэрэг засаж, хатгалдахаар зэхэж байсан  
ажгуу. Чингис хаан, Ван хаан хоёр хатгалдъя хэмээн цэрэг засаж, хүрч ирээд,  
орой боллоо, маргааш хатгалдъя зэрэгцэн хонов. Тэнд Ван хан буйран дээрээ гал  
түлүүлж орхиод, шөнө Хар сүүл /голын нэр/ өөд хөдлөн явжээ" хэмээн өгүүлсэн нь  
бий.

Мөн ХҮИ зууны үед 1686 онд Халхын Түшээт хан Чахундорж, Сэцэн хан  
Норов, Сайн ноён хан Шамба, Засагт хан Шар, Өндөр гэгээн Занабазар, Төвдийн  
ширээт лам Галдан түүний орчуулагчаар Ламын гэгээн Лувсанданзанжанцан

нарын 60 гаруй ноёд, тайж, зайсан нар тус бүр 20 орчим шадар дагуултай оролцон Халх аймгуудын хоорондын тэмцэл, Монгол түмний хувь заяаны асуудлыг тунгаан болгоож байсан түүхтэй газар юм. Энэ үйл явдал түүхэнд "Хүрэн бэлчрийн чуулган" хэмээн тэмдэглэгджээ.

Монголын түүхтэй салшгүй холбоотой Их эзэн Чингис хаан цэргээ засаж, Монголын ноёд чуулж байсан түүхэн газар нутгаас нум сумны зэв ихээр олддог бөгөөд археологийн дурсгалаар баялаг түүхэн газар юм.

Хожим энэхүү эртний түүхэн дурсгалт газрыг мөнхжүүлж "Заг-Байдрагийн Хүрэн бэлчир"-ийн Чандмань овооноо "Их Монголын нөөлгөн гал эндээс уулгалсныг бид мартахгүй" хөшөө Эзэн Богд Чингис хааныг 9 өрлөгийн хамт гэрэлт хөшөө болгон мөнхөлж Чингис хааны хоногдосон газарт тусгайлан дурсгалын хөшөө босгосон байдаг.

Заг-Байдрагийн Хүрэн бэлчир бол ийнхүү Монгол улсын түүхт газар төдийгүй Хонгор нутгийн "Аялал жуулчлалын онцгой нөөц бүтээгдэхүүн - Аялал жуулчлалын түшиц тулгуур газар" юм.

**Дөрөв. Тэмцээний төрөл:**

Үндэсний их сурын цуваа харваа

Уламжлалт /зэвт/ харваа

Сарамбай харваа

Бөмбөг намнах харваа

Холч харваа

Өсвөр насны Үндэсний сурын харваа гэсэн 6 төрөл байна.

**Тав. Харваанд оролцох журам:**

Харваа нь Монголын үндэсний их сурын харваа, Уламжлалт харваа, Холч харваа, Саранбай харвааны дүрмийн дагуу явагдана.

**Үндэсний Их Сурын цуваа харваа:**

Үндэсний их сурын харвааны дүрмийн дагуу харваа тэмцээнийг явуулна. Эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны ангиллаар зохиогдоно.

Үндэсний сурын харваанд эвэр элэгтэй, шөрмөсөн артай нум, 5ш модон сумтай оролцоно. /Нуманы бариул, нуман дээр нэмэлт тоноглол, хэрэгсэл хийж байрлуулах зэргээр хэлбэр загварыг өөрчлөхийг хориглоно/

**Уламжлалт /зэвт/ харваа:**

Эрэгтэй 40м 50м 60м зайнд, Эмэгтэй 20м 30м 40м зайнд тус бүр 1x1 метрийн хэмжээтэй байнд тус бүрд 5 сум, нийт 15 сум харвааны дүнгээр шигшээ

3.

харвааг явуулж шалгаруулна. Байны онооны 5-1 оноо. Нум харгалзахгүй, модон болон хулсан сумаар харвана.

**Саранбай харваа:**

Саранбай харвааны дүрмээр явагдана. Эрэгтэй, эмэгтэй төрлөөр 30м зайны газраас 1,25 метрийн өндөрт тогтоосон 45м тойрогтой байнд 5 сумаар 3 удаа босож нийт 15 сум харвана. Оноо тэнцсэн тохиолдолд наран гол их гаргасан оноогоор тооцно. Бүх оноо тэнцсэн тохиолдолд товх харвана. Нум харгалзахгүй, хулсан ба модон үүсгэртэй байна. Төмөр тахтай сумаар харвахгүй/

**Бөмбөг намнах:**

Эрэгтэй, эмэгтэй харваачид оролцоно. Газраас 1,5 метрийн өндөрт тогтоосон 30х30 хэмжээтэй бөөрөнхий хэлбэрийн байг 50 метрээс нэг харваач 5 сумаар 3 удаа нийт 15 сум харваж оноог дүгнэнэ. Харваач нь 5-с илүү сумтай босохыг хориглоно. Нум харгалзахгүй модон болон хулсан сумаар харвана.

**Холч харваа:**

Эрэгтэй, эмэгтэй төрлөөр харваа явагдах талбайд тусгайлан заагдсан тэмдэгт чиглэлд харваач нь 2 хүртэл сум харвах ба нум харгалзахгүй. /Модон сумтай шувууны өдтэй байна/

**Өсвөр насны Үндэсний сурын харваа :**

9-11 нас, 12 - 14 нас, 15 - 17 насны эрэгтэй, эмэгтэй ангиллаар дүрмийн дагуу явагдана.

**Зургаа. Бай шагнал:**

Харвуул тэмцээний төрөл тус бүрд эхний 5 байрт орсон харваачдад медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл гардуулна.

**Долоо. Ерөнхий ивээн тэтгэгч:**

- Монгол Улсын Байгаль орчин, Аялал жуулчлалын яам
- Монгол Улсын Гадаад харилцааны яам
- Монгол Улсын Соёлын яам

**Найм. Ерөнхий зохион байгуулагч:**

- Баянхонгор аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар
- Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар
- Монголын Үндэсний Харваачдын холбоо
- Баянхонгор аймгийн Үндэсний сурын холбоо

Заг, Жаргалант, Гурванбулаг, Баянбулаг, Галуут, Бууцагаан, Бөмбөгөр,  
Баян-Овоо, Хүрээмарал сумын ИТХ, ЗДТГ

**Ес: Тэмцээний зохион байгуулалт:**

Монголын Үндэсний Харваачдын холбоо, Баянхонгор аймгийн Үндэсний сурын холбооноос томилогдсон Ерөнхий шүүгч болон шүүгчдийн бүрэлдэхүүн удирдан явуулна.

Тэмцээнд оролцогсод "Отог"-ийн зохион байгуулалттай байна.

Бэлтгэл болон харвааны үед харваачдыг зохион байгуулах, сахилга дэг журамтай байлгах ажлыг "Отог"-ийн ахлагч хариуцна.

Нийт харваачид **"Аюулгүй байдлын зааварчилгаа"**-тай танилцаж гарын үсэг зурсан байна.

Харваачид өөрийн Үндэсний дээл хувцастай байна.

Тэмцээний явцад удирдамж болон дүрмийг зөрчсөн харваачийг тэмцээнээс хасна.

Харвааны бүртгэлийн хураамж 40.000 төгрөг байна. Бүртгэгдсэн харваач хэдэн ч төрөлд оролцож болно. Бүртгэлийн хураамжийг Баянхонгор аймгийн Үндэсний сурын холбооны /Хаан банк 5225407811/ дансанд тушаана.

Харвуул тэмцээнд оролцох Улс, аймаг, хот, орон нутгийн болон гадаадын харьяат харваачдын бүртгэлийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 10 -ны өдөр хүртэл цахимаар болон холбогдох утсаар авна.

Мэдүүлгийг Facebook хаяг: **Баянхонгор аймгийн Үндэсний сурын холбоо** цахим хаягаар болон Утас: **89303797, 99007576** -аар тус тус хүлээж авна.

**Таны хараа нь хуриц**

**Нум нь хүчтэй**

**Сум нь мэргэн**

**Уухай нь цээл байх болтугай**

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_